

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ, ТҮР СААТУУЛАХ ХАШАА АЖИЛЛУУЛАХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалт, Хууль зүйн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалаар батлагдсан "Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Тээврийн хэрэгсэл түр хадгалах байрны ажиллах журам"-г нэгдүгээр, "Тээврийн хэрэгслийг түр саатуулах байрны төлбөр, хураамжийн хэмжээ"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга цагдаагийн хурандаа (**Б.Баатархүү**)-д даалгасугай.

3. Захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлэхийг сумын Засаг дарга (Ж.Жавхаатөгс)-д үүрэг болгосугай.

Баруун-Урт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны ... сарын ...-ний өдрийн
Ээлжит хуралдааны тоот тогтоолын
нэгдүгээр хавсралт

Тээврийн хэрэгсэл түр хадгалах байрны ажиллах журам

- 1.1. Энэхүү журмын зорилго нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох замын хөдөлгөөнд оролцогчдын хэвийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор авто хэрэгслийг түр саатуулан, эзэмшигчид нь хүлээлгэн өгөх хүртэлх үйл ажиллагааг гүйцэтгэхэд чиглэгдэнэ.
- 1.2. Цагдаагийн эрх бүхий албан хаагчийн шийдвэргүйгээр түр саатуулах байранд тээврийн хэрэгсэл байрлуулах, гаргахыг хориглоно.

Хоёр: Тээврийн хэрэгсэл түр хадгалах байрны ерөнхий нөхцөлд, шаардлага

- 2.1. Тээврийн хэрэгсэл түр хадгалах байр нь хаалганаас өөр газраар нэвтрэх боломжгүйгээр хийгдсэн байна.
- 2.2. Түр саатуулагдсан тээврийн хэрэгсэлтэй холбоотой зөрчлийг арилгуулах, зохих хариуцлагыг Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тасгаас томилогдсон байцаагч шийдвэрлэх бөгөөд хоногийн төлбөрийг энэхүү журмаар батлагдсан тарифын дагуу дансанд мөнгийг тушаалгаж, баримтаар нь тооцох үүргийг түр саатуулах байрны жижүүр гүйцэтгэнэ.
- 2.3. Түр саатуулах байранд тээврийн хэрэгслийг 2 сараас илүүгүй хугацаатай хадгалах бөгөөд 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэл тээврийн хэрэгсэл гаргахыг хориглоно.
- 2 сараас илүү хугацаагаар хадгалагдсан тээврийн хэрэгслийн эзэн хобогдогчийг тогтоон буцаан өгөх арга хэмжээг зохион байгуулна.
- 2.4. Түр хадгалах байр нь шөнийн цагт буюу үзэгдэх орчин хангалтгүй үед бүрэн харах бололцоо бүхий гэрэлтүүлэгтэй камерийн системтэй байна.
- 2.5. Түр хадгалах байр нь болзошгүй аюулаас сэргийлэх зорилгоор даатгагдсан байна. Даатгалын төлбөрийг түр хадгалах байрны хураамжаас төлнө.
- 2.6. Түр хадгалах байрны сахиул нь саатуулагдаж байгаа тээврийн хэрэгслийн орж ирсэн цагийг бүртгэж, буруутай этгээдийг байлцуулан, гарын үсэг зуралцан хүлээн авах, хүлээлгэн өгөх асуудлыг шийдвэрлэнэ. Зөрчил доголдол гаргаж хохирол учруулсан нөхцөлд буруутан хохирлыг барагдуулна.
- 2.7. Сахиул солигдсон нөхцөлд зохих байгууллагуудаас оролцсон ажлын хэсэг гарч, нүдээр үзэж тоолж бүрэн бүтэн байдлыг сайтар хүлээлцэнэ.
- 2.8. Энэхүү үйл ажиллагаанд аруун-урт сумын засаг даргын тамгын газрын дарга, захирагчийн албаны барилга, дэд бүтэц, газар зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн биечлэн хяналт тавьж хадгалах байрны жижүүр санхүүгийн болоод бусад зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлж, илэрсэн зөрчил дутагдлыг нэн даруй шийдвэрлэж ажиллана.

Гурав: Сахиулын ажиллах журам

3.1. Тээврийн хэрэгсэл түр хадгалах байрны сахиул нь саатуулах үндэслэл бүхий тээврийн хэрэгслийн хүлээн авна.

3.2. Тээврийн хэрэгслийг хүлээн авахдаа гадна дотно тал, багаж, бүхээг, тэвшинд үзлэг хийж эд ангиудын бүрэн бүтэн байдал бүхээг тэвшинд ачсан ачаа зэргийг бүртгэлд нэг бүрчлэн тусгаж, авч ирсэн ажилтан, жолооч нараар гарын үсэг зуруулж хүлээн авна. Үзлэгийн явцад гэмт хэргийн ул мөр, тэсэрч дэлбэрэх бодис, шатах тослох материал гэх мэт зүйлс илэрвэл холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

3.3. Тээврийн хэрэгслийн хаалга, багажийг заавал түгжүүлсэн байх ба түгжигдэхгүй нөхцөлд бүртгэлд тусгаж эзэмшигчээр гарын үсэг зуруулна.

3.4. Сахиул нь согтуугаар ажил үүргээ гүйцэтгэх, ажлын байраа хараа хяналтгүй орхин явах, мал амьтан, тээврийн хэрэгсэл, эд анги зэргийг алдаж үрэгдүүлэх, зөрчил доголдол гаргасан бол ажлаас халах үндэслэл болно.

Дөрөв: Хоногийн төлбөрт тавих хяналт

4.1. Саатуулагдсан тээврийн хэрэгслийн хоногийн төлбөрийг тус журмаар батлагдсан тарифын дагуу тооцож, баруун-Урт сумын 100121300955 тоот дансанд тушаалган, баримтыг хадгалах байрны жижүүрт хүлээлгэн өгсөний дараа тээврийн хэрэгсэл гаргах зөвшөөрлийг Замын цагдаагийн тасгийн албан хаагч эзэн холбогдогчид олгоно. Хадгалах байрны жижүүр нь энэхүү бичгийг үндэслэн тээврийн хэрэгслийг гаргаж “Зөрчил шийдвэрлэх бүртгэлийн дэвтэр”-т тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулан хүлээлгэн өгнө.

4.2. Хадгалах байрны жижүүр Зөрчил шийдвэрлэх дэвтэрт шийдвэрлэлтийн талаар нэг бүрчлэн бичиж, 7 хоног бүр дүнг нэгтгэн, бүртгэл хөтөлсөн байх шаардлагатай ба мягмар гараг бүрийн Засаг даргын Тамгын газрын шуурхай хуралдаанд тээврийн хэрэгсэл хадгалах байрны нөхцөлд байдлын мэдээг танилцуулж, сар бүрийн 30-ны өдрөөр тасалбар болгон хадгалагдсан тээврийн хэрэгслийн жагсаалтыг хадгалах байрны бүртгэлтэй тулгалт хийж, Баруун-Урт хотын захирагчийн албаны дэд бүтэц, тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн, санхүүгийн албаар хянуулан, холбогдох материалыг хүлээлгэн өгч баталгаажуулна.

4.3. Хоногийн төлбөрийг хадгалах байрнаас тээврийн хэрэгслийг гаргасан өдрөөс тасалбар болгон тооцож авах ба хадгалагдсан хоногийг дутуу тооцсон, зохих зөвшөөрлийн бичиггүйгээр саатуулах байрнаас тээврийн хэрэгслийг дур мэдэн гаргасан, санхүүгийн баримтыг үрэгдүүлсэн, санхүүгийн журмыг зөрчсөн тохиолдолд буруутай албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож шийдвэрлэнэ.

Тав. Хоногийн төлбөрийг авах

5.1. Дээрх үндэслэлээр тээврийн хэрэгслийн хадгалагдсан үеэс эхлэн хоногийн төлбөрийг тооцох буюу тээврийн хэрэгслийг хадгалахтай холбогдсон зардлыг буруутай этгээд болон тухайн тээврийн хэрэгсэл хариуцсан байгууллагаар төлүүлнэ.

5.2. Саатуулагдсан тээврийн хэрэгслийн төлбөрийг тус журмаар батлагдсан тарифын дагуу тооцож, Баруун-Урт сумын.....дансанд тушааж баримтаар тооцоог хийнэ.
/бэлэн мөнгөөр тооцоо хийхгүй/

5.3. Зам тээврийн осол, хэрэг болон бусад төрлийн гэмт хэргийн улмаас саатуулагдсан Цагдаа болон Шүүхийн шийдвэрээр битүүмжлэгдсэн, эд мөрийн баримтаар хураагдсан зэрэг шалтгаанаар саатуулагдаж /удаан хугацагаар хадгалагдсан/ тээврийн хэрэгслийг Шүүх, Прокурор, Цагдаагийн байгууллагын албан тушаалтны гаргасан шийдвэрийг үндэслэн хоногийн төлбөрийг тооцож хадгалах байрнаас гаргана.

5.4. Энэхүү журмын 5.3-д зааснаас бусад шалтгаанаар саатуулагдсан тээврийн хэрэгслээс хадгалах байранд байсан хугацааны шууд зардлыг хариуцагч байгууллага, иргэдээс хоногоор тооцож авна.

5.5. Тооцоо хийгээгүй, зохих байгууллагын шийдвэр ирээгүй нөхцөлд саатуулах байрны сахиул/манаач/ дур мэдэн тээврийн хэрэгслийг хөдөлгөхийг хориглоно.

Зургаа. Хоногийн төлбөрөөс чөлөөлөх нөхцөл

6.1. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, захиргааны зөрчлийн улмаас хадгалагдсан тээврийн хэрэгслийн жолооч нас барсан, гэм буруугүй нь нотлогдсон тохиолдолд хоногийн төлбөрөөс чөлөөлнө.

6.1. Мөрдөгч, прокурорын шийдвэрийн дагуу эрүүгийн хэрэг хураагдсан, битүүмжлэгдсэн болон бусад үндэслэлээр саатуулагдсан тээврийн хэрэгслийг эрүүгийн хэрэг эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд журмын хашаанд түр байршуулж болох ба тээврийн хэрэгслийн бүртгэл, бүрэн байдлыг тухайн хэргийг шалгаж буй мөрдөгч хариуцна.

6.2 Гэмт хэргийн улмаас түр байршуулсан тээврийн хэрэгслийг төлбөрөөс чөлөөлнө.

Долоо. Төлбөр хураамжийн зарцуулалт

7.1. тээврийн хэрэгсэл хадгалах байрны хоногийн төлбөрөөс орсон орлогоос тухайн байрны үйл ажиллагааны зардалд зарцуулна.

7.2.Төлбөр хураамжийн орсон орлогоос гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд зарцуулна.